

МОНГОЛ УЛС: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ - 2006

*Б.Ганзориг**,
*Д.Начин***

1. Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 122 дугаар тогтоолын дагуу Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэр, дэд бүтэц /барилга, мэдээлэл, харилцаа холбоо, эрчим хүч/-ийн салбаруудын хүрээнд 2006 оны 9 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Засгийн газрын ордонд зохион байгуулав. Уг чуулга уулзалтыг Монгол Улсын Засгийн газар, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, Монгол банк, Euromoney Conferences-аас хамтран зохион байгуулсан.

2. Чуулга уулзалтын бэлтгэл ажил

Чуулга уулзалтын бэлтгэл Forbes Asia, Newsweek, Businessweek, Fortune, Wall Street Journal, The Japan Times, El Mundo, Le Point, Euromoney зэрэг дэлхийд нэр хүнд бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр агентлагийн удирдлагаас ярилцлага өгөх арга хэмжээгээр гадаад сурталчилгаагаар эхэлсэн бөгөөд чуулга уулзалтын цаасан урилгыг хэвлүүлж Монгол Улсаас гадаад орнуудад суугаа ЭСЯамд, өргөмжит консулууд, дипломат төлөөлөгчийн газруудаар болон Дэлхийн хөрөнгө оруулалтын агентлагуудын холбоо (WAIPA)-гоор дамжуулан гишүүн орнуудын оролцогчдод хүргүүлсэн.

Засгийн газрын 8 салбарын 43 төслийг нэгтгэн Засгийн газрын хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийн танилцуулгыг¹ хэвлэн дэлхийн хэмжээний томоохон хөрөнгө оруулагчдад биетээр болон агентлагийн вэб хуудаст тавьж сурталчиллаа.

Хувийн хэвшлийн 40 гаруй төслүүдийг нэгтгэн авч, чуулга уулзалтын вэб хуудас дээр байрлуулан хөрөнгө оруулагч нарт сурталчлав.

Хөрөнгө оруулалтын хөтөч, Хөрөнгө оруулагчдын гарын авлага, Экспортлогчдын лавлахуудыг CD хэлбэрт оруулан бэлтгэж чуулга уулзалтанд оролцогч нарт тараалаа.

^{*} Б.Ганзориг - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга
^{**} Д.Начин - мөн агентлагийн ажилтан

Гадаад сурталчилгаа болон чуулга уулзалттай холбоотой мэдээллийг цаг алдалгүйгээр хүргэх зорилгоор чуулга уулзалтын www.investmongolia.com/forum цахим хуудсыг хийж интернэтэд байрлуулан олон улсын байгууллагууд, төрийн байгууллагууд, интернэт мэдээллийн цахим хуудаст холбоос хийн байрлуулсан, интернэтийн хайлтын хуудсуудад бүртгүүлэн сурталчилгаа хийж байв.

Чуулга уулзалтын тухай зарыг телевиз, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр хүргэж чуулга уулзалтанд оролцогчдын бүртгэлийг онлайн хэлбэрээр болон агентлаг дээр хийсэн болно.

3. Чуулга уулзалтанд оролцогчид

Чуулга уулзалтанд нийтдээ 805 төлөөлөгч оролцсоноос гадаадын 425, дотоодын 380. Гадаадаас БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, Франц, АНУ, Сингапур зэрэг 35 орноос төлөөлөгчид оролцож дээр дурьдсан салбаруудад хөрөнгө оруулалт хийх боломжийг судалдсан байна. Энэ удаагийн чуулга уулзалтанд Merrill Lynch, Moody's Inc, Gerald Metals Inc, Ericsson, Samsung, Mitsui, Sumitomo, Mitsubushi, Seimens, ING Group, Carlsberg, Renova, POSCO, JP Morgan зэрэг үндэстэн дамнасан корпорациудын гүйцэтгэх захирал, ерөнхий менежерүүд, төрийн ба төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид, Канад, Франц зэрэг өндөр хөгжилтэй орнуудаас Бээжинд суугаа Элчин сайдын яамдын тэргүүн, худалдаа эдийн засгийн зөвлөхүүд, Польш, Тайвань, Чех улсуудын худалдааны танхимын төлөөлөгчид оролцов.

4. Чуулга уулзалт

Чуулга уулзалтын нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд оролцож үг хэлснээс гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээг Ерөнхийлөгчийн зөвлөх Б.Намхайжанцан, УИХ-ын даргын мэндчилгээг Төсвийн байнгын хороон дарга Ч.Улаан нар уншиж сонсгов. Euromoney Institutional Investor-ын гүйцэтгэх захирал Tony Shale-ийн мэндчилгээ хүргэж үг хэлсний дараа Сангийн сайд Н.Баяртсайхан Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдлын тухай илтгэл тавьж, Үйлдвэр худалдааны сайд Б.Жаргалсайхан үг хэлэв. Дараа нь Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ш.Сүхбаатар, Монгол банкны Ерөнхийлөгч О.Чулуунбат, Татварын ерөнхий газрын дэд дарга Б.Ариунсан, ГХОГХА-ийн дарга Б.Ганзориг, Олон улсын валютын сангийн Ази, Номхон далайн газрын зөвлөх Roger Kronenberg, Дэлхийн

банкны Монгол дахь суурин төлөөлөгч Arshad M.Sayed нар илтгэл тавив. Илтгэлүүдийн хооронд Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, Монгол дахь санхүүгийн салбарын хөгжил, Дэлхийн хэмжээний хөрөнгө оруулагчид, Монгол дахь хөрөнгө оруулалтын боломжууд сэдвээр 3 хэлэлцүүлэг хийв. Хэлэлцүүлгүүдийг Моодис санхүүгийн байгууллагын Sovereign Risk группийн дэд ерөнхийлөгч Thomas Вуте, Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын Санхүү, худалдаа, хамтын ажиллагааны хэлтсийн захирал Barry J.Hitchcock, LIM зөвлөх компанийн гүйцэтгэх захирал Dean Van Drasek нар удирдан явуулж, Европын Холбооны /Монгол болон Хятад дахь Европын Хорооны төлөөлөгч, “Эдийн засаг болон Нийгмийн шинэчлэл” салбарын тэргүүн, хамтын ажиллагаа, хөгжлийг хариуцсан нэгдүгээр нарийн бичгийн дарга Rudie Filon, ING Банкны Ази Номхон далайн газрын дарга Florian Schmidt нарын шинжээчид оролцов.

Чуулга уулзалтын хоёрдахь өдөр буюу 2006 оны 09 дүгээр сарын 15 – ны өдөр салбар хуралдаануудыг яамдын төрийн нарийн бичгийн дарга нар нь удирдан хэлэлцүүлэг хэлбэрээр хийж, сайд нар нь мэндчилгээ хүргэж, илтгэл тавьж оролцов.²

Салбар хуралдаанууд дээр Засгийн газрын болон хувийн хэвшлийн томоохон 18 төслийг танилцуулсан.

5. Чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнүүд

- Үзэсгэлэн

Чуулга уулзалтын үеэр Төрийн ордонд зохион байгуулагдсан үзэсгэлэнд дотоод, гадаадын компани, банк, санхүүгийн нийт 33 байгууллага³ оролцож, сурталчилгаа, танилцуулга хийсэн. Энэ үзэсгэлэнд Merryll Lynch, ING Group зэрэг дэлхийд нэр хүнд бүхий үндэстэн дамнасан корпорациуд ирж оролцон байгууллагынхаа үйл ажиллагааны талаар танилцуулж, Монголын бизнес эрхлэгч нартай хамтран ажиллах боломжийг судласан.

- Танилцах аялал

Чуулга уулзалтанд оролцсон сонирхсон оролцогчдыг ТЭЦ -4 – дулааны цахилгаан станц, Говь ХК, Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр,

Женко тур компанийн *13 дугаар зууны парк*-тай танилцах аялал зохион байгуулсан.

- Дугуй ширээний уулзалт

Чуулга уулзалт өндөрлөсний дараа ГХОГХА, Хаан банк, Монгол банк, MCS групп, Euromoney Conferences, Худалдаа, хөгжлийн банкны удирдлагуудын дугуй ширээний уулзалт, ярилцлага болсон.

6. Чуулга уулзалтын үеэр хийгдсэн уулзалтууд, яригдсан төслүүд

1. Францын дэд бүтцийн бүтээн байгуулалт, барилга угсралтын том компани болох Bouygues корпорацийн хөрөнгө оруулагч Quan Montana тэргүүтэй төлөөлөгчид Нисэх буудлын хотхон төсөл болон бусад асуудлаар Эрүүл мэндийн, Зам тээвэр, аялал жуулчлалын, Барилга, хот байгуулалтын яамдын холбогдох албан тушаалтнуудтай тус тус уулзалт, ярилцлага хийв.

2. Эгийн гол, Чаргайтын усан цахилгаан станцыг барих, Улаанбаатар-Мандалговь-Оюутолгой-Тавантолгойн чиглэлд эрчим хвч шилжүүлэх 220 кВт хоолойн холболтын төсөл, Засгийн газраас үзүүлэх дэмжлэгийг ч танилцуулав.

3. Merryll Lynch, ING Group-ууд Монголын Засгийн газрын 300-500 сая ам.долларын бондыг дэлхийн хөрөнгийн зах зээл дээр гаргах санал тавьж Монгол банк болон холбогдох яамд, газруудтай анхан шатны хэлэлцээр хийсэн байна.

4. Бельги, АНУ-ын хөрөнгө оруулалттай 250 сая ам.долларын “Морин нуур” төслийн талаар мэдээлэл хийгдсэн. Жилдээ 300 мянган хүнд үйлчлэх боломжтой аялал жуулчлалын уг цогцолборыг Айдсын давааны зүүн талд барих төслийн менежментийг “Merryll Lynch” групп хийх ажээ.

5. Өвлийн аялал жуулчлал, анхны томоохон цанын бааз Монголд, Гачуурт тосгоны орчим байгуулах төслийг хөрөнгө оруулагчдад танилцууллаа. Жилдээ 45 мянган хүнд үйлчлэх хүчин чадалтай уг цанын баазад 3.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд тоног төхөөрөмжийг Австри улсаас авахаар төсөлд тусгажээ.

6. Чех, Монголын хоорондын худалдааг дэмжихэд компьютерийн сүлжээг ашиглах төслийг Европын холбоогоор дамжуулан хэрэгжүүлэх талаар санал солилцсон уулзалт Чехийн эдийн засгийн танхим, ГХОГХА-ийн төлөөлөгчдийн хооронд болов.

7. Монголын худалдаа, үйлдвэрлэлийн компаниуд, ӨМӨЗО-ы худалдаа, бизнесийн байгууллагууд хооронд хамтран ажиллах санамж бичиг, худалдааны гэрээ -нийтдээ 15 баримт бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагаа болов.

1. Эдгээр төслөөс заримыг нь нэрлэвээс:

- Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн 3 төсөл,
 - үйлдвэрлэлийн технологийн паркийг бий болгох, хөгжүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын 2 төсөл,
 - Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд, тэдгээрийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлийн 4 төсөл,
 - Саалийн үнээний ферм байгуулах, мах боловсруулах, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны системийг хөгжүүлж малчдын орлогыг нэмэгдүүлэх хүнс, хөдөө аж ахуйн салбарын 7 төсөл,
 - Мангуш, Эгийн гол, Онон, Чаргайт, Булган, Баянтэсийн усан цахилгаан станцууд, Чойрын салхин фермийн түлш, эрчим хүчний чиглэлийн 12 төсөл,
 - 40 000 айлын орон сууц, олон улсын нисэх буудлын хотхон, хот суурин газруудын цэвэр усны хангамжийн байгууламж зэрэг барилга, хот байгуулалтын чиглэлийн 9 төсөл,
 - Цахим Монгол Мэдээлэл, харилцаа холбооны төсөл,
 - Аялал жуулчлалын хүний нөөцийн хөгжил, Бичигт хад, Extreme Sport-ийн цогцолбор барих, адал явдалт аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг зам тээвэр, аялал жуулчлалын чиглэлийн 4 төсөл энэ номонд багтсан байна.
2. - Д.Тэрбишдагва - Хүнс, Хөдөө Аж Ахуйн Сайд
- Б.Эрдэнэбат – Түлш, эрчим хүчний Сайд
 - Ц.Дашдорж – Барилга, хот байгуулалтын Дэд сайд
 - Б.Жаргалсайхан – Үйлдвэр, худалдааны Сайд
 - Ц.Цэнгэл – Аялал жуулчлал, зам тээврийн Сайд
 - Ч.Сайханбилэг – Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газрын дарга

- Ц.Даваадорж – ҮХСайдын зөвлөх, ҮХЯамны Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга нар салбар хуралдааны гол илтгэгчдээр оролцсон.
3. ГХОГХА, Монгол банк, Алтанбулагийн чөлөөт бүсийн захирагчийн алба, Замын-Үүдийн чөлөөт бүсийн захирагчийн алба, Банк санхүүгийн Merrill Lynch, ING Group, Чингис Хаан банк, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Мобиком, Говь, АПУ, Монос групп, Жуулчин, Монгол даатгал зэрэг нийт 33 компани.